




НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ**

Улаанбаатар хот
2021 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны Б/08 дугаартай “Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх тухай” тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын /НАГ-2021/86-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумьяабазар/, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Г.Энхтайван/-т тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг аудитын гуравдугаар хэлтэс /Э.Мөнхмандах/-т үүрэг болгосугай.

4. Тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:

Хуудас

Аудитын гуравдугаар
хэлтсийн дарга, аудитын
менежер:

Товчилсон үгийн тайлбар

2

Э.Мөнхмандах

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товьёг

3

Аудитын менежер:

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт,
арга зүйн талаарх мэдэгдэл

4-5

Б.Номинбаатар

Ерөнхий мэдээлэл

6-7

Аудитор:

Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт
үндэслэлтэй хийгдсэн үү;

8-11

Д.Дариймаа

Ч.Чулуун-Эрдэнэ

Бүлэг 2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу
зохион байгуулагдсан уу;

12-19

Б.Ууганбилэг

Гэрээт ажилтан

Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу;

20-25

О.Оргил

Дүгнэлт

26

2021 оны 5 дугаар сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар тодруулах,
асууж лавлах зүйл байвал
327787 дугаарын утсаар
харилцана уу.

Зөвлөмж

27

Холбогдох байгууллагын санал

28-29

Саналд өгсөн тайлбар

30-32

Тайланг НТАГ-ын
www.audit.mn цахим
хуудаснаас үзнэ үү.

Хавсралтууд

33-55

Хаяг:

14200, Сүхбаатар дүүрэг, 8
дугаар хороо, Г.Амарын
гудамж-2, Соёлын төв
Өргөө, Г корпус, НТАГ



Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЭЗБТХ	Эдийн засаг бодлого төлөвлөлтийн хэлтэс
НДАА	Нийслэлийн Дотоод аудитын алба
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НАЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НӨАУГ	Нийслэлийн Өмч ашиглалтын удирдлагын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТББ	Тендерийн баримт бичиг
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НМТГ	Нийслэлийн Мэдээлэл технологийн газар
УБХК	Улаанбаатар хөгжлийн корпорац
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НАЖГ	Нийслэлийн Аялал жуулчлалын газар
НСУГ	Нийслэлийн Соёл урлагийн газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар
НШУҮИГ	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар
ХТГ ОНӨААТҮГ	“Хот тохижилтын газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УБГХХОДХ Төсөл	Улаанбаатар хотын гэр хороолол хөгжүүлэх хөрөнгө оруулалт дэмжих хөтөлбөр төсөл
УБЗЗАГ ОНӨААТҮГ	Улаанбаатар зам, засвар, ашиглалтын газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХТСИ ОНӨААТҮГ	Хот төлөвлөлт, судалгааны институт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НМЭГ	Нийслэлийн Мал эмнэлгийн газар
ДХААА	Дүүргийн худалдан авах ажиллагааны алба
НӨАУГ	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
ЖДҮД	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
НД	Налайх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлтийн жагсаалт	8
Хүснэгт №2	НИТХ-аас 3 удаагийн тогтоолоор баталсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг, 2020 онд санхүүжих дүн	9
Хүснэгт №3	НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа	12
Хүснэгт №4	Эрх шилжсэн ТАХ, түүврээр шалгасан ТАХ	13
Хүснэгт №5	2019, 2020 онуудад Нийслэлийн 9 дүүргийн ХААА-д эрх шилжсэн ТАХ	14
Хүснэгт №6	Үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал	16
Хүснэгт №7	Шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулаагүй байгууллагууд	17
Хүснэгт №8	Хуульд нийцээгүй аргаар зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт	18
Хүснэгт №9	НИТХ-ын 9/36, 02/06 тогтоолоор батлагдсан санхүүжих дүн	22-23

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Ерөнхий нэрээр буюу нэр байршил тодорхойгүй баталсан ТАХ-ний задаргаа	10
Дүрслэл №2	2019, 2020 онуудад Нийслэлийн 9 дүүргийн ХААА-д эрх шилжсэн ТАХ	14
Дүрслэл №3	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, 2020 онд нэр, байршил, тоо тодорхойгүй ТАХ	25

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Тогтоолд орсон өөрчлөлтөөр хасагдаж, нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт (2020 онд хэрэгжих)	33-36
Хавсралт №2	Тогтоолд орсон өөрчлөлтөөр нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт (он дамжин хэрэгжих)	37
Хавсралт №3	Ерөнхий нэрээр баталсан ТАХ-ний жагсаалт	38-39
Хавсралт №4	Үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал	40-46
Хавсралт №5	Шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулаагүй байгууллагууд	47-54
Хавсралт №6	Гэрээний хэрэгжилтэд алданги тооцсон ажлын жагсаалт	55



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, МҮЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаал, НТАГ-ын 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилт	Энэхүү аудит нь 2020 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү; ➤ Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан уу; ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг НЗДТГ-ын СТСХ, ЭЗБТХ, УБЗАА, НХААГ, НАЗХГ, НХОГ, зарим агентлаг болон дүүргүүдийн ХААА, холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Төрийн аудитын тухай хууль, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах заавар, Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх зааврыг ашиглаж, шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөө, тайлан, бусад шаардлагатай материалд дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, нягтлан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа. Дараах хууль эрх зүйн актуудыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан. Үүнд: Төсвийн тухай, Барилгын тухай, Авто замын тухай, ТБОНӨХБАҮХАТ, ЗГ-ын 2013 оны 68, 2018 оны 129 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”, 2012 оны “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”, Сангийн сайдын 2017 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”; 2016 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”, НИТХ-ын 2020 оны төсөв баталсан тогтоолууд.
Аудитын стандартын талаарх мэдэгдэл:	Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын АДБОУС 300, АДБОУС 3000, АДБОУС 3100, “Төрийн хяналт шалгалтын стандарт”-ыг тус тус мөрдөж ажиллав.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, аудитор Д.Дариймаа, аудитор Ч.Чулуун-эрдэнэ, Б.Ууганбилэг, Гэрээт ажилтан О.Оргил нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.

Хүндрэл бэрхшээл

НТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөр /2021.01.04-05.03/, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хугацаа сунгасан төлөвлөгөө, хөтөлбөр /2021.01.04-05.10/, мөн аудитын түүвэрт хамрагдаагүй нэмэлт ажлын дагуу сунгасан /2021.01.04-05.20/ хугацаанд гүйцэтгэхэд Ковид-2019 цар тахлын улмаас Улсын онцгой комиссоос улс даяар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т удаа дараа шилжүүлсэн байдал нь шалгагдагч байгууллага болон талбарт ажиллах, баримт материал татах, тулган баталгаажуулахад хүндрэл бэрхшээлтэй байсан.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2¹ дэх заалтын дагуу нийслэлийн хэмжээнд НИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 29/31 дугаар тогтоолоор нийслэлийн төсөв болон замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 1,561,404.5 сая төгрөгийн төсөв өртөгтэй 2020 онд санхүүжих дүнгээр 404,848.7 сая төгрөгийн 204 багц ТАХ буюу 2020 онд шинээр хэрэгжих 1,217,605.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн онд санхүүжих дүнгээр 314,045.2 сая төгрөг бүхий 117 багц ТАХ, өмнөх оноос дамжин хэрэгжих 343,798.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий санхүүжих дүнгээр 90,803.5 сая төгрөгийн 87 багц ТАХ баталсан байна.

Дээрх 29/31 тогтоолд нийт 3 удаа нэмэлт өөрчлөлт орж, ТАХ-ний тоог 227 багц, төсөвт өртгийг 857,451.4 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүнг 726,989.4 сая төгрөгөөр баталсан байна. 2020 онд шинээр хэрэгжих ТАХ-нд орсон өөрчлөлтийг харуулбал:

- 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 9/36 тогтоолоор ТАХ-г 120 багц болгож 3 ТАХ-ээр өсгөж, тухайн онд санхүүжих дүнг 301,031.5 сая төгрөг болгон бууруулсан.
- 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 33/07 тогтоолоор 1,400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 ТАХ-г шинээр нэмсэн.
- 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн II-02/06 тогтоолоор нийт ТАХ-г 138 багц буюу 626 ТАХ, тухайн онд санхүүжих дүнг 176,403.5 сая төгрөг болгон баталсан байна.

ТАХ-ний эрхийг нийслэл, дүүргийн төрийн захиргааны 37 байгууллагад шилжүүлж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаа, боловсон хүчний нөөц, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн хэмжээ ихтэй уялдуулан 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт ТАХ-нээс ажлын төсөвт өртөг, байршил, шинж байдал, хэрэгжилтийн хувь, гүйцэтгэл зэрэг шалтгаануудаар тухайн онд санхүүжих 92,893.2 сая төгрөгийн дүнтэй 227² ТАХ буюу 36.2 хувийг түүвэрлэн авч худалдан авах ажиллагаа, гүйцэтгэл, санхүүжилтийн материалуудыг хамруулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын явцад түүвэрт хамрагдсан 18,840.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7,185.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 ТАХ-г “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.4³ дэх заалтын хүрээнд аудитад бүрэн хамрагдаагүй. Үүнд:

- “Нийслэлийн Цагдаагийн газар, Тээврийн цагдаагийн хэлтсийн хөдөлгөөнт эргүүлийн туулах чадвар сайтай автомашин” 7,550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, НЗДТГ-т эрх шилжүүлж хэрэгжүүлсэн;

¹ 8.5.2.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;

² Түүвэрт хамруулахдаа батлагдсан төсөвт өртгийг ангиллаар нь тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, тохижилт, барилга, засвар, зам засварын ажлуудыг түүвэрт 100% хамруулсан.

³ 3.4.Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.



- “Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний зориулалтын автомашин /40ш/” 4,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, НЗДТГ-т эрх шилжүүлж хэрэгжүүлсэн;
- “Улаанбаатар хотын авто машин, гудамж талбайд RFID систем нэвтрүүлэх” 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, НМТГ-т эрх шилжүүлж хэрэгжүүлсэн;
- “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, төлөвлөлтийн систем” 1,490.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, НХААГ-т эрх шилжүүлж хэрэгжүүлсэн;

Дээрх 18,840.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г хассанаар 498,835.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 223 ТАХ буюу 35.6 хувийг хамруулав.

**БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХИЙГДСЭН ҮҮ.****1.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө бодлогын баримт бичигтэй уялдуулсан уу.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтод нийцүүлж, нийслэлд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний үр ашгийг тооцон, хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

“Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны мөрийн хөтөлбөр”-ийн 1-5 дугаар бүлэг, “Нийслэлийн нийгэм эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг тулган баталгаажуулахад 138 багц буюу 626 ТАХ-ний 99,3 хувь буюу 622 ТАХ-г нийцүүлэн төлөвлөжээ. /Хүснэгт №1/

Хүснэгт №1. Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлтийн жагсаалт

(сая.төг)

№	Нэр, батлагдсан он, сар, өдөр, дугаар	Тогтоолын					
		ТАХ хэрэгжих он	Батлагдсан			Өсөлт / бууралт	
			тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг Санхүүжих дүн
1	“Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай” 2019.12.02-ны өдрийн 29/31 дугаар	2020 онд	117	1,217,605.6	314,045.2		
		Он дамжих	87	343,798.9	90,803.4		
		НИЙТ	204	1,561,404.5	404,848.6		
2	“Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны “Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай” 29/31 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2019.12.16-ны өдрийн 9/36 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2020.05.14-ны өдрийн 33/07 дугаар	2020 онд	120	1,229,463.0	301,031.5	3	11,857.4 (13,013.7)
		Он дамжих	89	345,018.9	91,585.9	2	1,220.0 782.55
		НИЙТ	209	1,574,481.9	392,617.4	5	13,077.4 (12,231.2)
3	“Нийслэлийн 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2020.11.13-ны өдрийн II-02/06 дугаар	2020 онд	2	1,400.0	700.0		
4	“Нийслэлийн 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2020.11.13-ны өдрийн II-02/06 дугаар	2020 онд	138	512,432.5	176,403.5	18	(717,030.5) (124,628.0)
		Он дамжих	89	345,018.9	91,585.9	-	- -
		НИЙТ	227	857,451.4	267,989.4	18	(717,030.5) (124,628.0)

Тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр шинээр хэрэгжих 69 ТАХ нэмэгдэж, 2 ТАХ хасагдсанаар нийт 717,030.5 сая төгрөгөөр төсөвт өртөг буурсан байна.

Нэмэлт, өөрчлөлт орсон ажлын нэр, тоо, төсөвт өртгийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав. Хавсралт №1, 2

Дүгнэлт: Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх 138 багц ТАХ-ний 99,3 хувийг хөрөнгө оруулалтын богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан баталсан байна.



1.2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагын саналд үндэслэж, эрэмбэлсэн үү.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4⁴ дэх заалтын дагуу хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний талаар Нийслэл, дүүргийн төрийн байгууллага, нэгжээс дүүрэг, хорооны байршил, хэмжих нэгж, хүчин чадал, төсөвт өртөг, хэрэгжүүлэх болон санхүүжүүлэх хугацаа, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, хүртэх үр ашиг зэрэг үзүүлэлтүүдээр санал⁵ авахад, нийт 2000 орчим санал ирүүлжээ.

Нийслэл, дүүргийн төрийн байгууллага, нэгжээс ирүүлсэн нийт 2000 орчим санал ирүүлснээс НЗДТГ холбогдох үзүүлэлтийн дагуу боловсруулалт хийж, эрэмбэлжээ.

НИТХ-ын тогтоолоор баталсан 117-138 багц ТАХ-ний хамгийн их хувийг барилга угсралт, зам засвар, арчлалтын ажил, хамгийн бага хувийг нөхөн олговортой холбоотой ажил эзэлж байна. /Хүснэгт №2/

Хүснэгт №2. НИТХ-ын тогтоолоор баталсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг, 2020 онд санхүүжих дүн

(сая.төг)

№	ТАХ ангилал	2019.12.02 29/31			2019.12.16 9/36			2020.11.13 II-02/06		
		ТАХ тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	ТАХ тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	ТАХ тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1	Барилга угсралт	39	559.3	103.7	39	459.3	101.4	29	241.9	36.6
2	Гэрэлтүүлэг	2	5.7	3.2	2	5.7	3.2	2	4.2	0.5
3	Зам засвар, арчлалт	29	211.9	92.3	32	213.7	77.6	57	137.5	61.8
4	Засвар	12	13.5	5.7	12	13.5	5.7	13	8.0	3.6
5	Зураг төсөв	4	10.1	1.5	4	10.1	1.5	3	2.7	1.2
6	Нөхөн олговор	1	50.0	20.0	1	50.0	20.0	1	20.0	20.0
7	Тоног төхөөрөмж	20	319.9	48.4	20	419.9	48.4	20	56.9	22.2
8	Тохижилт	10	47.2	39.3	10	57.2	43.8	13	41.1	30.3
	НИЙТ	117	1217.6	314.1	120	1229.4	301.6	138	512.3	176.2

Дүгнэлт: Нийслэлийн 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагын саналд үндэслэж, эрэмбэлсэн байна.

⁴ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

⁵ НЗД-ын 2019 оны 06 дугаар сарын 24-ний 01/2670 дугаартай албан бичиг




1.3. Хууль, журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан уу.

Аудитаар нийслэлийн 2020 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2019.12.16 9/36 тогтоолоор баталсан 120 багц ТАХ-ний нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой эсэхийг тулгахад Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁶, 29.4⁷ заалтыг зөрчиж 661,698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тухай онд санхүүжих дүнгээр 155.830.3 сая төгрөгийн 38 багц ТАХ-г тодорхойгүй буюу хууль, журамд заасан шаардлагыг бүрэн хангаагүй ерөнхий нэрээр баталсан байна. Тухайлбал:

- “Нийтийн тээврийн шинэ шийдэл төсөл, парк шинэчлэлт, хүүхдийн сургуулийн автобус” нэртэй 350,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажил” нэртэй 16,408.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар” нэртэй 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар” нэртэй 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

Ажлын ерөнхий нэр, төсөвт өртөг, тодорхойгүй байдлын мэдээллийг хавсралтаар харуулав. Хавсралт №3

Дүрслэл №1. Ерөнхий нэрээр буюу нэр байршил тодорхойгүй баталсан ТАХ-ний задаргаа



Ерөнхий нэрээр баталсан ТАХ-г нэр, байршил тодорхойлон тусгаж эрх шилжүүлэн хэрэгжүүлсний дараа ИТХ-аар нэр байршлыг баталжээ. Тухайлбал:

“Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажил” 16,408.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ ерөнхий байдлаар батлагдсан бөгөөд НЗД-ийн 2020 оны 01 сарын 20-ны өдрийн А/38 захирамжаар “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, Сүхбаатарын талбайн урд байрлах Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийн ажил”-ыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-т эрх шилжүүлэн хэрэгжүүлсний дараа 2020 оны 11 сарын 23-ны 02-06 тогтоолоор нэр байршлыг нөхөн баталсан байна. Мөн зарим ТАХ-г 3-45 хүртэл нарийвчлан задалсан байна.

ТАХ-ний нэр, байршил тодорхойгүй буюу ерөнхий нэрээр тусгагдсан нь бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, эрэмбэлсэн ач холбогдлыг бууруулж хөрөнгө оруулалтын төсөв хэрэгцээ, шаардлагатай ажилд бүрэн төлөвлөгдөхгүй байх, улмаар анх төлөвлөгдсөн ТАХ болон төсөвт өртөг өөрчлөгдөх, зураг төсөвгүй батлагдах, өөр

⁶ 29.3.4. “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;”

⁷ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээ тусгана.



ажилд зарцуулагдах зэргээр Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁸, 29.4⁹-т заасныг зөрчигдөх эрсдэлийг үүсгэж, сонгон шалгаруулалт, ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийн хугацаа алдагдах нөхцөлд хүргэж байна.

Мөн төсөв төлөвлөх, батлах үеийн хяналт буюу НИТХ-ын бүлэг, хороод, ажлын хэсэг, төлөөлөгч нарын оролцоо, идэвх, ажил хэрэгч байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан ч хуулийн болон нийтийн хэрэгцээ, шаардлага хангаагүй, хэт ерөнхий нэрээр багцалж баталжээ.

⁸ “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”;

⁹ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөөт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээ тусгана.



БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН УУ.

2.1. Захиалагчийн эрх шилжүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан уу

2020 оны нийслэлийн төсвийг 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталж, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр тодотгосон байна.

Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13¹⁰-т эрх шилжүүлэх хугацааг төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байхаар заажээ.

ТЕЗ-аас 2020 онд хэрэгжиж эхлэх нийт 512,407.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 370 ТАХ-г дээрх хугацаанд багтаан эрх шилжүүлсэн, харин 645,999.7 сая төгрөгийн төсөвтэй 256 ТАХ-ний эрхийг НЗД-аас эрх шилжүүлэхдээ 5-134 хоногийн хугацаагаар хоцроож буюу 2020.03.02-10.12-ны хооронд шилжүүлсэн байна.

НЗД нь эрх шилжсэн 256 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг холбогдох харьяа газруудад 5-134 хоногийн дараа шилжүүлжээ.

Хүснэгт №3. НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа

№	Эрх шилжсэн газар	Тоо	ТАХ-ний Төсөвт өртөг (сая.төг)	Хоцроосон хугацаа /хоног-р/
1	БНД-ийн ХААА	6	1,570.6	5-27
2	БХД-ийн ХААА	2	314.4	27-53
3	УБЗАА	44	11,127.5	27-57
4	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	3	6,549.5	37-114
5	ЗХУТ НӨҮГ	1	1,000.0	59
6	НАЖГ	1	10.0	82
7	НАЗХГ	42	25,362.0	7-156
8	НГЗБА	1	64,558.0	3-94
9	НД-ийн ХААА	18	2,124.2	5-83
10	НЗДТГ	3	9,498.9	63
11	НМТГ	12	19,000.0	47
12	НСУГ	4	200.0	27
13	НХААГ	28	77,854.2	7-63
14	НХБХГ	32	766.2	19
15	НШҮҮИГ	2	125.6	63
16	УБ лифт ОНӨТҮГ	1	78.6	7
17	УБГХХХОДХ Төсөл	18	109,037.1	3-159
18	УБЗЗАГ ОНӨААТҮГ	34	12,611.2	11-82
19	УБХК ХК	1	374,700.0	27
20	ХТГ ОНӨААТҮГ	2	549.3	50-74
21	ХТСИ ОНӨААТҮГ	1	17.900	134
	НИЙТ	256	717,055.2	5-134

ТЕЗ-аас эрхийг дээрх байдлаар хугацаа хоцроож шилжүүлж байгаа нь тухайн ТАХ төлөвлөгдсөн хугацаанд дуусахгүй байх, тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай ТАХ хэрэгжиж эхлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

НЗД-ын 145 удаагийн захирамжаар харьяа 37 байгууллагад эрхийг шилжүүлж, ХАА-г зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг даалгасан байна.

¹⁰ 2.13.Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор,хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.

**Хүснэгт №4. Эрх шилжсэн ТАХ, түүврээр шалгасан ТАХ 9/36 дугаар тогтоолоор**

(сая.төг)

№	Эрх шилжсэн	НИТХ-ын 9/36 дугаар тогтоолоор батлагдсан ТАХ			Түүврээр шалгасан ТАХ		
		Тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1	Авто бааз УТҮГ	6	500.0	500.0	2	408.0	408.0
2	БНД	13	20,340.8	4,856.3	9	4,786.3	2,806.3
3	БХД	8	5,964.3	1,914.7	5	2,334.3	1,384.7
4	ГУББГ ОНӨААТҮГ	14	4,000.0	2,000.0	-	-	-
5	ЗАА	61	21,581.2	5,492.6	45	11,921.3	5,402.5
6	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	1	1,500.0	800.0	1	1,500.0	800.0
7	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	9	23,800.0	7,300.0	-	-	-
8	ЗХУТ НӨҮГ	23	2,000.0	1,390.0	-	-	-
9	НАЖГ	2	10.0	10.0	-	-	-
10	НАЗХГ	83	89,971.1	48,867.2	24	15,471.3	6,269.3
11	НАЗХГ, УБЗЗАГ ОНӨААТҮГ	1	2,744.0	900.0	-	-	-
12	НАЗХГ, ХУД	1	1,000.0	500.0	-	-	-
13	НГЗБА	2	52,819.6	22,819.6	-	-	-
14	НД	21	3,529.6	2,698.0	12	3,194.4	2,362.8
15	НЗДТГ	4	14,299.0	7,034.0	4	14,299.0	7,034.0
16	НМТГ	12	19,000.0	4,710.0	1	5,000.0	600.0
17	НМЭГ	1	1,600.0	500.0	1	1,600.0	500.0
18	НОСК ХК	4	101,757.2	10,841.2	-	-	-
19	НСУГ	4	200.0	200.0	2	136.6	136.6
20	НХААГ	170	238,914.2	39,941.8	90	122,912.7	23,330.4
21	НХААГ, НАЗХГ	4	12,346.2	1,300.0	-	-	-
22	НХААГ, НГЗБА	3	9,826.5	1,200.0	-	-	-
23	НХААГ, НД	2	2,094.0	1,094.0	-	-	-
24	НХААГ, УБЗЗАГ ОНӨААТҮГ	2	11,200.0	4,000.0	-	-	-
25	НХААГ, ЧД	1	1,200.0	500.0	-	-	-
26	НХБХГ	32	766.3	766.3	-	-	-
27	НХОГ	28	177,583.6	61,845.0	6	14,229.8	3,588.1
28	НШУУИГ	2	125.6	125.6	2	125.6	125.6
29	СХД	7	13,000.0	3,400.0	3	5,600.0	1,500.0
30	УБ лифт ОНӨТҮГ	1	78.6	78.6	-	-	-
31	УБГХХХОДХ Төсөл, НХОГ	30	22,176.6	22,176.6	-	-	-
32	УБЗЗАГ ОНӨААТҮГ	35	14,111.2	9,918.2	16	11,492.0	7,899.0
33	УБХК ХК	1	347,700.0	23,750.0	1	347,700.0	23,750.0
34	ХТГ ОНӨААТҮГ	3	4,337.7	4,337.7	2	4,337.7	4,337.7
35	ХТСИ ОНӨААТҮГ	31	805.8	805.8	-	-	-
36	ХУД	1	2,200.0	500.0	-	-	-
37	ЧД	1	750.0	658.2	1	750.0	658.2
38	Захирамж гараагүй	2	3,630.00	1,300.00	-	-	-
НИЙТ		626	1,229,463.1	301,031.4	227	567,799.0	92,893.2

Аудитаар түүвэрлэн үзсэн 92,893.2 сая төгрөгийн санхүүжих үнийн дүнтэй 227 ТАХ-ний 90 буюу 39.6%-ийг мэргэжлийн эрх бүхий байгууллага буюу НХААГ, 45 буюу 19.8%-ийг УБЗЗАА, 24 буюу 10.6%-ийг НАЗХГ, бусад 68 буюу 30.0%-ийг бусад агентлаг дүүргүүдэд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

2020 онд хэрэгжсэн ТАХ-ний ХАА-г НХААГ болон агентлагуудын АЗ гэрчилгээтэй ажилтнууд төрийн захиалагч байгууллага гэдгээр зохион байгуулсан хэдий ч эрх шилжиж, хэрэгжсэн ТАХ-ний сонгон шалгаруулалтад зохион байгуулалтын алдаа, дутагдал багагүй илэрч байна.

Дээрх агентлагууд нь тайлан мэдээгээ НХААГ-т тогтоосон хугацаанд ирүүлдэггүй, дутуу ирүүлдэг алдаа дутагдлууд давтагддаг байна.

Зөрчил, дутагдлын дэлгэрэнгүйг аудитын тайлангийн дэд зорилт 2.2, 2.3-аас үзнэ үү.

Энэ нь, чиг үүрэг өөр байгууллагын ажилтны ажлын ачаалал нэмэгддэг, арга зүйн заавар, чиглэл, хяналт дутагдалтай байгаа зэргээс шалтгаалж цаашид ХАА-ны



эрх бүхий байгууллагад эрхийг шилжүүлж, нэгдсэн арга зүй, хяналт, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх шаардлагатай байна.

Захиалагчаас эрх шилжүүлж хэрэгжүүлсэн ТАХ-нүүдийн ХАА-г зохион байгуулсан байгууллагаар нь өмнөх онтой харьцуулбал:

- 2019 онд: НХААГ-150, агентлагууд 589, Дүүргүүдийн ХААА-283 ТАХ;
- 2020 онд: НХААГ-170, агентлагууд 403, Дүүргүүдийн ХААА-51 ТАХ-ний ХАА-г тус тус зохион байгуулсан байна.


ТБОНӨХБАҮХАТ хуулийн 53.2¹¹ тусгагдсан үүрэг бүхий нэгж нийслэл, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа боловч дээрх төсөл, арга хэмжээний 64.6%-ийг нийслэлийн харьяа ХАА-ны чиг үүрэггүй агентлагуудад эрх шилжүүлсэн нь ХАА-ны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимтай нийцэхгүй байна.

Хүснэгт №5. 2019, 2020 онуудад Нийслэлийн 9 дүүргийн ХААА-нд эрх шилжсэн ТАХ

№	Дүүргийн нэр	2019 онд эрх шилжүүлсэн ТАХ		2020 онд эрх шилжүүлсэн ТАХ	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Баянгол	16	557.0	-	-
2	Баянзүрх	27	660.0	-	-
3	Хан-Уул	35	557.0	1	2,200.0
4	Сонгинохайрхан	80	8,206.0	7	13,000.0
5	Сүхбаатар	49	537.6	-	-
6	Чингэлтэй	5	608.0	1	750.0
7	Налайх	15	1,185.9	21	3,529.6
8	Багануур	31	12,038.4	13	20,340.8
9	Багахангай	25	823.8	8	5,964.3
	НИЙТ	283	25,173.7	51	45,787.7

Дүрслэл №3. Графикаар харуулбал:

2019, 2020 онуудад Нийслэлийн 9 дүүргийн ХААА-нд эрх шилжсэн ТАХ



¹¹ 53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.



Дүгнэлт: ТЕЗ-аас 2020 онд хэрэгжүүлэх ТАХ-ний 370 буюу 59.1%-ийг хуулийн хугацаанд нь эрх шилжүүлж, 256 буюу 40.9%-г хуулийн хугацаанд нь эрх шилжүүлээгүй хоцроосон, ХАА-ны эрх бүхий байгууллагын оролцоог багасгаж бусад агентлаг, байгууллагуудад эрх шилжүүлж байгаа нь захиалагчийн эрх шилжүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжихгүй байна .

2.2. Үнэлгээний хорооны үйл ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан уу

Аудитад хамрагдсан ТАХ-нд давхардсан тоогоор 107 үнэлгээний хороо байгуулагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. НЗД-ын 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан “Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны ХАА-ны ерөнхий төлөвлөгөө”-нд худалдан авах хугацааг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Үнэлгээний хороо байгуулагдах огноо 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр
- Тендер зарлах огноо 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр
- Гэрээ байгуулах эрх олгох огноо 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдөр гэж заасан.

Гэтэл НЗД-аас эрх шилжин хэрэгжсэн ТАХ-г НХААГ, ДХААА, агентлагууд нь үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш дунджаар 90-346 хоног зарцуулж сонгон шалгаруулалт явуулж зарим ТАХ нь НИТХ-ын II-02/06 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр хасагдсан байна. Тухайлбал:

- *НХААГ-ын 2020.02.07 А/20 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны “131 дүгээр цэцэрлэгийн засвар”/БНД, 1 дүгээр хороо/, 49.8 сая төгрөг 220 хоног;*
- *НХААГ-ын 2020.01.24 А/08 тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны “НОВА өрхийн эмнэлгийн сантехникийн засвар”/БЗД, 20 дугаар хороо 15.0 сая төгрөг 346 хоног;*
- *НАЗХГ-ын 2020.04.06 А/23 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны “Саппорогийн уулзвараас Баянбүрдийн тойрог хүртэлх 4.7км дугуйн зам /Ард Аюушийн өргөн чөлөө, Л.Энэбишийн өргөн чөлөө/ /СХД, БГД/ 5,452.0 сая төгрөг 184 хоног;*

Дээрх үнэлгээний хороод нь үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл ихээхэн хугацаа зарцуулж, барилгын ажил гүйцэтгэх дулааны улирал өнгөрсөн үед зөвлөмж гарч байгаа нь хөрөнгө оруулалтын ажил он дамжин хийгдэх, төсөв татагдах зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Аудитын түүвэрт хамруулан тулган баталгаажуулалт хийсэн ТАХ-нээс ХАА-а зохион байгуулахтай холбоотой, эрх зүйн акт зөрчсөн нийт 22,746.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 52 ТАХ байна. Тухайлбал:

- ТББ-ийн эрх зүйн үндэслэл, баримт бичгийн бүрдэл, заалтыг бүрэн хангаагүй “Он саргүй” тодорхой бусаар баталсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19 дүгээр зүйл, 22 дугаар зүйлийн 22.1¹² тус тус зөрчсөн;
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” заалтыг зөрчиж хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаагүй, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтын дагуу зарим үнэлгээний хороод

¹² Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй.



архивын нэгж үүсгээгүй баримт бичгийн бүрдэл дутуу зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Архивын баримт материалын бүрдэл дутуу байгаа нь тухайн тендер шалгаруулалт үнэн зөв, ил тод явсан эсэхийг нотлох боломжгүйд хүргэх эрсдэлтэй байна.

Хүснэгт №6. Үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал

№	ТАХ зохион байгуулсан газар	Төсөвт өртөг (сая.төг)	ТББ он саргүй баталсан	Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдүүлэг бөглөөгүй	Олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаагүй	АЗ гэрчилгээ	Архивын нэгж үүсгээгүй
1	НХААГ	6,745.9	6	2	3	1	-
2	НАЗХГ	9,731.5	12	-	-	-	13
3	НХОГ	2,584.5	3	-	-	-	-
4	НЗДТГ	27.4	1	-	-	-	1
5	УБЗАА	230.1	-	5	-	-	5
6	БХД ХАА	340.7	-	-	-	2	-
7	НСУГ	133.4	2	-	-	-	2
8	УБЗЗАГ ОНӨААТҮГ	1,454.1	13	-	1	2	-
9	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ НИЙТ	1,498.9	1	-	1	-	-
		22,746.5	38	7	5	5	21

Ажлын нэр, төсөвт өртөг, зөрчил, дутагдлын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав. Хавсралт № 4

ХАА-ны эрхийг шилжүүлэхдээ ХАА-ны эрх бүхий байгууллагад шилжүүлээгүйгээс зарим агентлагууд батлагдсан ТАХ-ний төсөвт өртгийг дур мэдэн задалж харьцуулалтын аргаар зохион байгуулж, худалдан авах ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн байна. Үүнд:

- НШУҮИГ-ын даргын 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/67 тушаалаар батлагдсан 79.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баянхошуу бизнес инкубатор дэд төв Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж” нийлүүлэх ХАА-г зохион байгуулсан үнэлгээний хороо нь батлагдсан төсөвт өртгийг 49.2 сая, 29.7 сая болгон хувааж харьцуулалтын аргаар зохион байгуулж, тус ТАХ-г үр дүнгүй зохион байгуулж хөрөнгө татагдсан байна.

Дүгнэлт: ХАА зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн акт зөрчсөн нийт 22,746.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 52 ТАХ байна. Цаашид ХАА зохион байгуулахдаа Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

2.3. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн түүвэрт хамрагдсан ТАХ-д шалгарсан гүйцэтгэгчийн материалыг тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлттэй тулган шалгахад 38,777.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 57 төсөл, арга хэмжээнд шалгуур хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3 “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” заалтыг зөрчжээ.



Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа, үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмуудыг мөрдөөгүй, ТББ-д тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, ижил төстэй хийж гүйцэтгэсэн ажил, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.3¹³ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Хүснэгт №7. Шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулаагүй байгууллагууд

№	Тендер зохион байгуулсан газар	Төсөвт өртөг (сая.төг)	Санхүүгийн чадавхи	Инженер техникийн ажилчдын чадавхи	Машин тоног төхөөрөмж	Ижил төстэй ажил	НД-ын тодорхойлолт	Татварын тодорхойлолт	Банкны толохуйлолт	Улсын бүртгэлийн гэрчилгээ
1	НЗДТГ	27.4	-	1	-	-	-	-	-	1
2	УБЗАА	1,684.7	6	10	5	-	-	-	-	-
3	НХААГ	20,225.6	1	6	1	2	-	-	-	-
4	НАЗХГ	6,219.1	-	-	6	6	-	-	-	-
5	НХОГ	2,172.7	1	3	1	-	-	-	-	-
6	УБЗЗАГ	528.8	-	-	-	1	2	2	-	-
7	Авто бааз УТҮГ	311.2	1	-	-	-	-	-	-	-
8	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	1,498.90	-	1	-	1	-	-	-	-
9	СХД	1,168.10	-	1	-	-	-	-	-	-
10	НД ХАА	1,769.5	2	4	-	1	1	2	2	1
11	БНД ХАА	2,431.90	1	4	-	1	-	-	1	-
12	БХД ХАА	339.7	2	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	38,377.6	14	31	13	12	4	4	3	2

Ажлын нэр, төсөвт өртөг, зөрчил, дутагдлын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав. Хавсралт № 5

Аудитын түүвэрт хамрагдсан 92,893.2 сая төгрөгийн санхүүжих үнийн дүнтэй 227 ТАХ-нээс нууцын зэрэглэлд хамаарах 7,185.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 ТАХ-нээс бусад 85,708.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 223 ТАХ байна. Үүнд:

- Харьцуулалтын аргаар 3,134.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 ТАХ;
- Шууд гэрээ байгуулах аргаар 33,198.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 ТАХ;
- Нээлттэй тендер сонгон шалгаруулах аргаар 48,502.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 196 ТАХ;
- Зөвлөх үйлчилгээний аргаар 378.6 сая төгрөгийн санхүүжих 5 ТАХ;
- Ажил эхлээгүй буюу газрын маргаантай 495.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 1 ТАХ байна. “Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга” /ЧД, 4 дүгээр хороо/

Шууд гэрээ байгуулсан ТАХ:

ХАА-ны аргыг хуулийн дагуу зохион байгуулсан боловч зарим ТАХ-г НЗД-аас “Хот тохижилтын газар”, “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-т эрх шилжүүлэн захирамжилж, шууд гэрээ байгуулж байгаа нь тендерийн аргыг буруу хэрэглэх, эсвэл хэрэглэхгүйгээр

¹³ 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.



өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр болж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁴-д зааснаар ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчимтай нийцэхгүй байна. Тухайлбал:

Хүснэгт №8. Хуульд нийцээгүй аргаар зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Эрх шилжүүлсэн шийдвэрийн		Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар	ХАА-нд мөрдөх журам (сая.төг)
			огноо	дугаар			
1	Сүхбаатарын талбайн урд байрлах Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийн ажил	3,788.3	2020.01.20	A/38	2,858.9	ХТГ ОНӨААТҮГ	Гэрээ шууд байгуулах арга
2	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд хэрэгжүүлэх “Блю ский” зочид буудлын зүүн талын гадна талбайн тохижилтын ажил	549.3	2020.06.15	A/822	549.3	ХТГ ОНӨААТҮГ	Гэрээ шууд байгуулах арга
3	Хотын гол болон туслах замуудын засварын ажил	3,899.0	2020.03.16	A/365	3,899.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	Гэрээ шууд байгуулах арга
4	Хотын гол болон туслах замуудын тэмдэг, хайс тоноглолын засвар арчлалтын ажил	2,000.0	2020.03.16	A/365	2,000.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	Гэрээ шууд байгуулах арга
5	Хотын гол болон туслах замуудын тэмдэглэгээний ажил	3,000.0	2020.03.16	A/365	3,000.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	Гэрээ шууд байгуулах арга
НИЙТ		9,448.3			9,448.3		

НЗД-аас 9,448.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 багц ТАХ-ний эрхийг “Хот тохижилтын газар” болон “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-т шилжүүлж, мөн гүйцэтгэгчээр сонгож ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуурыг магадлалгүйгээр шууд гэрээ байгуулжээ. Өмнөх жилийн аудитаар¹⁵ гарсан зөрчил дахин илэрч, туслан гүйцэтгэгчээр болон хөлсөөр ажиллуулах гэрээгээр иргэдийг ажиллуулсан байна. Эдгээр байгууллагын баримт, материалтай танилцахад дараах зөрчил, дутагдлууд илэрч байна. Тухайлбал:

- “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 2 ажилд 149 иргэн аж ахуй нэгжийг туслан гүйцэтгэгчээр ажиллуулсан боловч сонгон шалгаруулалт явуулсан баримт материал байхгүй.
- “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 3 ажилд туслан гүйцэтгэгчээр ажиллуулсан боловч сонгон шалгаруулалт явуулсан баримт материал байхгүй.

Мөн “УБЗЗАГ” ОНӨААТҮГ нь НЗД-ын 2020 оны 3 дугаар сарын 16-ны А/365 дугаар захирамжаар эрх шилжсэн дараах 2 ТАХ-ний төсөвт өртгийг багцлан хувааж

¹⁴ 6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹⁵ “НЗД болон НЗДТГ-ын хэлтэс, албадын дарга нар нь гүйцэтгэгчийн нэрийг урьдчилан тодруулж, тендерийн сонгон шалгаруулалт хийх үндсэн зарчмыг алдагдуулжээ. Улмаар эрх шилжүүлэх захирамжийн төслийг хянах, баталгаажуулахдаа өөрийн харъяаны УБЗЗАГ ОНӨААТҮГ-ын ажил гүйцэтгэх чадавхыг тооцоолохгүйгээр их хэмжээний төсөвт өртөгтэй ажлыг шууд нэр зааж өгсөн. Гэтэл хууль журмаар шууд гэрээ байгуулах тохиолдолд ерөнхий шалгуурыг магадлах заалттай боловч гүйцэтгэгчийн нэрийг зааж өгсөн нь үнэлгээний хороо хуулийг өөрөөр ойлгож мөрдөх нөхцөлийг үүсгэж, ХАА-ны хуульд заасан шалгуурыг баримтлахгүйгээр 2 хоногт зөвлөмж гаргасан байна. Мөн дээрх ажлуудыг анх гүйцэтгэхээр төлөвлөхдөө НАЗХГ-ын дарга, мэргэжилтнүүд УБЗЗАГ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэлд нь хяналт хийдэг мөртлөө чадавхыг үнэлээгүй, бодит санал өгөөгүй ажилдаа хариуцлагагүй ханджээ. Иймд дээрх ажлуудыг төлөөлөх, батлах, захирамжлах, хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн тухайн дарга, мэргэжилтнүүдийн үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчигдөж, албан тушаалын ашиг сонирхол үүссэн байх магадлалтай.”



ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5¹⁶-д заасныг зөрчиж нээлттэй тендер шалгаруулалтын аргаас зайлсхийж, харьцуулалтын аргаар ХАА-г зохион байгуулсан байна. Үүнд:

- ❖ Нөхөөс /УБЗЗАГ/ 1,729.0 сая төсөвт өртөгтэй;
- ❖ Заадас /УБЗЗАГ/ 1,100.0 сая төсөвт өртөгтэй;

Иймд дээрх ажлуудыг төлөвлөх, батлах, захирамжлах, хэрэгжүүлэхтэй холбоотой илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, газар, нэгж, албан тушаалтны ажлын уялдааг хангуулж, хариуцлагыг сайжруулах талаар НЗД болон НХААГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч шалгаруулсан 38,777.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 57 төсөл, арга хэмжээнд шалгуур хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан. ХАА-г зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй, гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагаа үр дүнгүй, хангалтгүй байна.

¹⁶ 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.



БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ.

3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, захиалагчийн хяналт үр дүнтэй байна уу

ТАХ-ний хэрэгжилтийн хувь, нэр төрөл, санхүүжилт зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан НЗД-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага болох НАЗХГ, НХОГ, УБЗАА-ны хэрэгжүүлсэн 28,081.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 60 ТАХ-г аудитын түүвэрт хамруулж, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчил, дутагдал гарч байна. Тухайлбал:

- “Богд хааны өвлийн ордны музейн орчимд цэцэрлэгт хүрээлэн байгуулах” /ХУД, 15 дугаар хороо/ 1,997.4 сая төгрөгийн ажилд гүйцэтгэгч “Сэнзо констракшн” ХХК нь 2019 онд тус ажлыг эхлүүлсэн, 2020 онд НТХО-аар тулган баталгаажуулалт хийхэд ажлын тоо хэмжээ дутуу гүйцэтгэлээр бүрэн хэрэгжээгүй байсан. 2021 оны байдлаар ажлын тоо хэмжээ дутуу чанарын шаардлага хангаагүй байдалтай хэвээр байна.
- “Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах” 495.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчээр Монкон Констракшн ХХК шалгарсан. Тус ТАХ-ний хувьд Ерөнхий боловсролын 11-н сургуулийн ойр орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэл, явган зам, авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэжээ. Гүйцэтгэлээр тулган баталгаажуулалт хийхэд хөдөлгөөн зохицуулах тэмдэг байршил бүрд тоо хэмжээний хувьд харилцан адилгүй, авто замын дагуу хайсыг чанаргүй суурилуулсан, хэвтээ тэмдэглэл арилж, бүдгэрсэн, явган замын эко хавтанг дутуу суурилуулсан, явган замын төгсгөл хэсгийг стандартын дагуу хийж гүйцэтгээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан рампыг суурилуулаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.
- “ЧД 5, 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт явган зам тавих, засварлах” 47.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчээр Арга билэг инженеринг ХХК шалгарсан. Гүйцэтгэлээр тулган баталгаажуулалт хийхэд чанарын шаардлага хангаагүй буюу явган замын төгсгөлийг хийгээгүй, хэд хэдэн газар эвдрэл өгсөн байдалтай байсан. Аудитын явцад гаргасан зөрчлийг арилгуулах, бүрэн дуусгах чиглэл өгсөн.
- “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайн тохижилтын ажил”-д НЗД-ын 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А/914 дугаартай “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон төсвийг НЗД-ын нөөц хөрөнгөнөөс гаргахаар тусгажээ. Ажлын хэсэг “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтуудын дагуу 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр “Боржин суварга чулуун урлал” ХХК-тай шууд худалдан авалтын аргаар 396 ширхэг боржин чулуу хашлагыг 40х40х40см саад 296ш, 1 ширхгийн үнэ 350,900 төгрөг, 50х50х50 см саад 100ш, 1 ширхгийн үнэ 453,750 төгрөг, нийт 152.2 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулжээ. Аудитаар бараа /Боржин чулуун хашлага, саад/-ны нийлүүлэлтийг шалгахад төвийн 5 дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагуудын 15 байршилд 331 ширхгийг байршуулж, 65 ширхэг нь байршуулагдаагүй буюу нийт бараа анх төлөвлөсөн байршилд хийгдээгүй, төсвийн хөрөнгийг хэрэгцээ, шаардлага багатай ажилд зарцуулжээ. Шалтгааныг



тодруулахад захиалагчийн шийдвэрээр байршлыг өөрчилсөн, гүйцэтгэгч гэрээний хугацаанд барааг нийлүүлж, урьдчилгаа 40%-ийн санхүүжилт авч, ажлын гүйцэтгэлээр үлдэгдэл санхүүжилтээ нэхэмжлэн шүүхэд гаргасан гомдол, маргаан эцэслээгүй зэрэг гүйцэтгэл болон санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байдалтай байна.

- “Хүүхдийн сургуулийн автобус” нийлүүлэх ажилд НЗД-ын 2020 оны А/463 дугаартай “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжаар зохион байгуулах эрхийг “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-д шилжүүлж, захиалагчийн хяналт хэрэгжүүлэхийг Нийтийн тээврийн үйлчилгээний газарт даалгасан. 2020 онд санхүүжих 23,050.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тус ТАХ нь төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааны хүрээнд “Моннис Моторс” ХХК-г гүйцэтгэгчээр шалгаруулж, 2020.07.02-нд гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу 2020 онд 75 ш, 2021 онд 75 ш, 2022 онд 50 ш автобус нийлүүлэх, үүнээс 2020 онд 1 ширхгийн үнийг 307,3 сая төгрөгөөр 75 ширхгийг нийлүүлэхээр тусгажээ. Аудитаар хүүхдийн сургуулийн автобусны нийлүүлэлтийг шалгахад гүйцэтгэгч нь 2020.08.03-ны өдөр 6,915.0 сая төгрөг буюу 23 ш хүүхдийн автобусны үнэлгээтэй тэнцэх санхүүжилт авсан боловч 5 ширхгийг нийлүүлж, эхний санхүүжилтэд хамаарах 18, гэрээний заалтад хамаарах үлдэгдэл нийт 70 ш хүүхдийн автобусыг хуваарьт заасан хугацаанд нийлүүлээгүй. Гэрээнд бараа нийлүүлэх тоо, хугацаа, нийлүүлэлт хуваарь, санхүүжилтийн хэлбэрийг нарийвчлан тусгаагүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын эрх үүргийг тодорхой бус захирамжилснаас захиалагч, гүйцэтгэгчийн ажлын хариуцлага алдагдаж, нийлүүлэлт удааширсан. Шалтгааныг тодруулахад 1 ш хүүхдийн автобусны 307,3 сая төгрөгийн үнэлгээг төлөвлөсөн тооцоолол, төсөв нотлох баримт холбогдох байгууллагуудад байхгүй бөгөөд гэрээнд тусгасан хүүхдийн автобусны нэгжийн үнэлгээ 307,3 сая төгрөг нь гаалийн мэдүүлгийн үнэлгээ 133,1 сая төгрөгөөс 174.2 сая төгрөгөөр буюу үнэлгээний зөрүү их байгаа шалтгааныг тооцоолох боломжгүй байна. Мөн 2020 оноос эхлэлтэй нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбогдон үйл ажиллагаа бүрэн явагдаагүй боловч гүйцэтгэгч нь БНХАУ-ын бараа үйлдвэрлэгчээс 2020.09.15-наас барааг нийлүүлэх боломжтойг дурдаад 2020.09.07-нд гэрээний үнийн дүнгийн 30 хувь буюу 2 дахь санхүүжилт болох 6,915.0 сая төгрөгийг нэхэмжилсэн байна. Энэ нь нийлүүлэлт хэвийн явагдах боломж байсныг харуулж байгаа бөгөөд захиалагч эхний санхүүжилтэд хамаарах 18 ш хүүхдийн автобус нийлүүлэгдээгүй байхад гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, харин ч гэрээ сунгах талаар шийдвэр гаргахаар ажиллаж, хариуцлагагүй ханджээ.
- “Сүхбаатарын талбайн урд байрлах Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийн ажил”-д НЗД-ийн 2020 оны А/38 дугаартай захирамжаар Хот тохижилтын газраар гүйцэтгэхийг даалгасан. Зураг төсөл боловсруулах ажлын 20/08 дугаар гэрээг Криетив Монголиа ХХК-тай 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр, НЗДТГ-тай Ажил гүйцэтгэх 3,224.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2020-А/38 дугаар гэрээг 2020 оны 3 дугаар сарын 9-ний өдөр тус тус байгуулсан байна. Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийн ажил гүйцэтгэх явцад 4,085.0 сая төгрөгийн төсөв боловсруулж, БХТ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 564/2020 дугаар магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр төсөвт өртөг 3,788.4 сая төгрөгөөр хянагдсан байна. Ажил гүйцэтгэх гэрээний 3-т “...Ажлын зураг, төсөв батлагдсаны дараа гэрээний үнэд өөрчлөлт оруулж



болно” гэж заасны дагуу 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний нийт дүнг 3,788.4 сая төгрөг болгон өөрчилсөн. ХТГ-аар зураг, төсвийн дагуу барилга байгууламж, тохижилтын үндсэн ажил, УСУГ-аар ус дамжуулах шугам, худгийн хэсгийг гүйцэтгүүлж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, ашиглалтад хүлээн авсан байна.

Хууль тогтоомжид заасан хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас 2,464.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 ТАХ-нд төсөвт тусгагдсан ажлыг дутуу болон чанаргүй хийх зэргээр гэрээний хугацааг хоцроож, үүргээ бүрэн биелүүлэхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4.¹⁷, 3.4¹⁸-д заасныг тус тус зөрчсөн.

Иймд илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, газар, нэгж, албан тушаалтны ажлын уялдааг хангуулж, хариуцлагыг сайжруулах талаар НЗД-д албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд зарим ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, хяналт үр дүнгүй байна.

3.2. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан уу

НИТХ-ын 2019 оны 9/36 тогтоолоор нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,229,463.0 төсөвт өртөг бүхий 626 ТАХ-ний 2020 онд санхүүжих дүн нь 301,031.4 сая төгрөг байхаар баталсан. Тус тогтоолд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 512,432.5 төсөвт өртөг бүхий 523 ТАХ-ний 2020 онд санхүүжих дүн нь 176,403.5 сая төгрөг байхаар баталж нийт ТАХ-ний төсөвт өртгийг 717,030.5 сая төгрөгөөр, ТАХ-г 103 тухайн онд санхүүжих дүнг 124,628.0 төгрөгөөр бууруулан баталсан байна. 2020 онд олгохоор батлагдсан 176,403.5 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэгч байгууллагад 171,543.9 сая төгрөг буюу 97.2%-ийг гүйцэтгэлд үндэслэн олгожээ.

Хүснэгт №9. НИТХ-ын 9/36, 02/06 тогтоолоор батлагдсан санхүүжих дүн

№	Эрх шилжсэн	НИТХ-ын 9/36 дугаар тогтоол			НИТХ-ын II-02/06 дугаар тогтоол		
		ТАХ тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	ТАХ тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1	Авто бааз УТҮГ	6	500.0	500.0	6	496.1	496.1
2	БНД	13	20,340.8	4,856.3	12	19,641.9	4,191.0
3	БХД	8	5,964.3	1,914.7	6	4,710.0	810.1
4	ГУББГ ОНӨААТҮГ	14	4,000.0	2,000.0	14	2,000.0	2,000.0
5	ЗАА	61	21,581.2	5,492.6	50	5,415.0	2,070.9
6	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	1	1,500.0	800.0	1	1,499.0	200.0
7	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	9	23,800.0	7,300.0	8	21,933.5	6,238.2
8	ЗХУТ НӨҮГ	23	2,000.0	1,390.0	23	1,387.2	1,115.1
9	НАЖГ	2	10.0	10.0	2	10.0	10.0
10	НАЗХГ	83	89,971.1	48,867.2	54	88,348.7	36,010.8
11	НАЗХГ, УБЗЗАГ ОНӨААТҮГ	1	2,744.0	900.0	1	2,744.0	2,744.0
12	НАЗХГ, ХУД	1	1,000.0	500.0	1	994.1	500.0
13	НГЗБА	2	52,819.6	22,819.6	2	22,819.6	22,819.6

¹⁷ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах

¹⁸ Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.



14	НД	21	3,529.6	2,698.0	16	2,348.4	1,672.3
15	НЗДТГ	4	14,299.0	7,034.0	3	12,354.2	5,165.5
16	НМТГ	12	19,000.0	4,710.0	9	5,870.3	699.4
17	НМЭГ	1	1,600.0	500.0	1	1,549.3	10.0
18	НОСК ХК	4	101,757.2	10,841.2	2	752.0	240.6
19	НСУГ	4	200.0	200.0	4	196.0	70.0
20	НХААГ	170	238,914.2	39,941.8	148	85,388.3	8,896.0
21	НХААГ, НАЗХГ	4	12,346.2	1,300.0	1	6,966.6	500.0
22	НХААГ, НГЗБА	3	9,826.5	1,200.0	2	1,499.6	550.0
23	НХААГ, НД	2	2,094.0	1,094.0	2	2,085.2	1,086.2
24	НХААГ, УБЗЗАГ ОНӨААТҮГ	2	11,200.0	4,000.0	2	11,200.0	6,549.4
25	НХААГ, ЧД	1	1,200.0	500.0	-	-	-
26	НХБХГ	32	766.3	766.3	28	404.7	292.5
27	НХОГ	28	177,583.6	61,845.0	24	143,464.5	32,775.9
28	НШУУИГ	2	125.6	125.6	1	46.4	46.4
29	СХД	7	13,000.0	3,400.0	4	8,227.2	1,350.0
30	УБ лифт ОНӨТҮГ	1	78.6	78.6	1	75.1	75.1
31	УБГХХХОДХ Төсөл, НХОГ	30	22,176.6	22,176.6	29	19,634.4	18,331.3
32	УБЗЗАГ ОНӨААТҮГ	35	14,111.2	9,918.2	32	10,309.4	8,309.5
33	УБХК ХК	1	347,700.0	23,750.0	1	23,050.0	6,915.0
34	ХТГ ОНӨААТҮГ	3	4,337.7	4,337.7	2	4,308.1	2,958.9
35	ХТСИ ОНӨААТҮГ	31	805.8	805.8	31	703.8	703.8
36	ХУД	1	2,200.0	500.0	-	-	-
37	ЧД	1	750.0	658.2	-	-	-
38	Захирамж гараагүй	2	3,630.00	1,300.00	-	-	-
НИЙТ		626	1,229,463.0	301,031.4	523	512,432.5	176,403.5

Аудитын түүвэрт хамрагдсан 223 ТАХ-нд НИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 13-ний II-02/06 дугаар тогтоолоор тодотгон 45,860.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 91.2 хувь буюу 41,822.7 сая төгрөгийг олгож, магадалшгүй ажил, техник хяналт, зураг төсөв, барьцаа 1,036.2 сая төгрөгийг суутган, 3,001.1 сая төгрөгийг гүйцэтгэлд үндэслэн он дамжин санхүүжүүлэхээр тооцож, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.

60 ажлын баримт болон ажлын талбар дээр хийгдсэн гүйцэтгэл, 123 ажлын санхүүжилтийн баримт, тооцоолол дээр тулгалт хийхэд захиалагчийн зүгээс ажлын гүйцэтгэлээр тооцож, хугацааг хэтрүүлсэн 2 ажилд 1.3 сая төгрөгийн алданги тооцсон байна.

Ажлын нэр, төсөвт өртөг, алданги тооцсон дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав. Хавсралт №6

Дүгнэлт: Санхүүжилтийг гэрээний гүйцэтгэлийн дагуу бүрэн тооцоолж, зарцуулсан байна.

3.3. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд авсан уу

НӨАУГ-аас нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлуудыг бүртгэлд тусгасан талаарх судалгаа авахад НЗД-ын захирамжаар хэрэгжсэн нийт 387 ТАХ-нээс 175-г НӨАУГ бүртгэх шийдвэр гаргах, 61 нь тухайн байгууллага өөрсдөө, 71 нь нийслэлийн өмчид бүртгэгдэхгүй, 80 нь он дамжин хэрэгжиж байгаа тул бүртгэлд хамрагдах хугацаа болоогүй.

Дээрх ажлуудаас Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжиж дууссан 20,510.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ буюу 10%-ийг НИТХ, НӨАУГ-ын шийдвэрээр бүртгэсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэлд тусгаж, эзэнжүүлэх асуудал бүхэлдээ удааширч байгаа ба шалтгааныг тодруулахад:

- Зарим ажлууд он дамжин хэрэгжихээр болсон.



- Хэрэгжиж дууссан ажлын өмчийн бүртгэлд оруулах мэдээлэл захиалагч байгууллагаас хугацаа алдаж ирдэг.
- Өмч, бүртгэлтэй холбоотой хууль, журмыг бүрэн мөрдөхгүй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаагүй байдал зэргээс шалтгаалж бүртгэх асуудал удаашралтай байна.

Үүнээс шалтгаалж төсвийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт алдагдах, хөрөнгө оруулалтын үр дүн буурах эрсдэлийг үүсгэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁹-д заасан заалтыг бүрэн мөрдөхгүй байна.

Дүгнэлт: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний 39 буюу 10%-ийг НИТХ, НӨАУГ-ын шийдвэрээр бүртгэсэн байна.

3.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгасан уу

Өмнөх аудитаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2, Нийслэлийн засаг даргад 1, нийт 3 зөвлөмжийг өгсөн. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтад нэр, газрын байршил, зөвшөөрөл, зураг төсөвтэй буюу төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хянаж, батлах;
- Үнэлгээний хороонд иргэний төлөөллийг сонгож батлахдаа ажил эрхлэлтийн байдал, түүнтэй уялдаатайгаар хуралд оролцох идэвх, боломж, ажлын тоо хэмжээ, улмаар хариуцлагын асуудлыг цалин, урамшуулалтай уялдуулан боловсруулах;

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлд захиалагчийн хяналт, өмчийн бүртгэлд тусгах үүрэг бүхий НЗДТГ, УБЗАА, НХААГ, НАЗХГ, НХОГ, НӨАУГ, “УБЗЗАГ” ОНӨААТҮГ, холбогдох байгууллагуудын ажилд хяналт тавьж, үр дүнг тооцож байх;

Дээрх байгууллагуудаас зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажлын мэдээ, тайлан ирүүлсэн боловч зөрчлүүд дахин илэрч байгаа нь зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйг харуулж байна. Тухайлбал:


- НИТХ-ын 2018 оны 20/17 дугаар тогтоолд тусгагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх 102 багц ТАХ-нээс 69,995.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 багц ТАХ-г тодорхойгүй буюу ерөнхий байдлаар баталсан ба зөрчлийг арилгуулах давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

Гэвч энэ онд буюу НИТХ-ын 2020 оны 9/36 дугаар тогтоолоор батлагдсан 2020 оны нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх 120 багц ТАХ-нээс 661,698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 багц ТАХ-г нэр, байршил, тоо тодорхойгүй буюу ерөнхий байдлаар тусган батлагдсан байна. Энэ нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгахгүй давтан гаргасаар байгаа буюу нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

¹⁹ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.



Дүрслэл №3. Үүнийг графикаар харуулбал:



Аудитаар илэрсэн зөрчил, үр дүнгээс харахад эрх бүхий хэрэгжүүлэгч агентлагуудад хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилт, ХАА-нд хууль эрх зүйн дүрэм журмыг бүрэн мөрдөөгүй, нарийн магадлаагүй, үнэлгээний хорооны үйл ажиллагааны үр дүн хангалтгүй, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, түүнд хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Энэ аудитаар тодорхой хэмжээний зөрчлүүд давтагдан гарч байгаа нь өмнө илэрсэн зөрчлийг арилгах талаар НИТХ, НЗД болон харьяа байгууллагын удирдлага, холбогдох ажилтнууд төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт: Төрийн Аудитын байгууллагын өмнөх аудитаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал өгсөн 1, Нийслэлийн засаг даргад өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, ажлын хариуцлага алдсан байна.

3.5. Төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна уу

Аудитаар илэрсэн зөрчил, үр дүнгээс харахад НТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртгийг нийт батлагдсан ТАХ-ний хэрэгжилт, гүйцэтгэл, гэрээ байгуулсан, он дамжсан, ажил гүйцэтгэлээр шалгарсан, хэрэгжиж эхэлснээс үл хамааран тооцоо судалгаанд нарийвчлан тусгаагүй, үндэслэлгүйгээр хассан нь хөрөнгө оруулалтын ажлын чанар, төсвийн санхүүжилтийн үр өгөөжийг дээшлүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн НТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөх, батлахдаа нарийвчлан тусгадаггүй ерөнхий нэрээр зураг төсөвгүй батлагддагаас шалтгаалан зохион байгуулалтад хүндрэл учрах, гүйцэтгэл удаашрах, батлагдсан эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй болох эрсдэл үүсэж, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжгүй байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл болон дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г бодлогын баримт бичигтэй уялдуулж, холбогдох байгууллагын саналд үндэслэж, эрэмбэлсэн ч хууль, журамд заасан шаардлагыг бүрэн хангаагүй төлөвлөж, баталсан байна.
2. ТЕЗ-аас 2020 онд хэрэгжүүлэх ТАХ-ний 370 буюу 59,2%-ийг хуулийн хугацаанд, 256 буюу 40,8%-г хугацаа хоцроож эрх шилжүүлснээс шалтгаалж ХАА зохион байгуулах ажил хойшлогдох, тухайн онд хэрэгжих боломжгүй болох зэргээр ТАХ-ний үр дүн хангалтгүй байна.
3. ХАА-ны эрх бүхий байгууллагын оролцоог багасгаж бусад агентлаг, байгууллагуудад эрх шилжүүлж, ХАА-г зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй, гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагаа үр дүнгүй, хангалтгүй байна.
4. ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгийн бүртгэл удааширсан, хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнгүй, өмнөх жилийн алдаа, дутагдал арилаагүй дахин илэрч, төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтад нэр, газрын байршил, зөвшөөрөл, зураг төсөвтэй буюу төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг эх үүсвэрээс нь үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр нь тусган баталж байх.
2. Хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хэлэлцэх, батлах болон төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад хороод, ажлын хэсэг, төлөөлөгч нарын хяналтыг сайжруулах.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хуулийн болон нийтийн хэрэгцээ, шаардлага хангагдаагүй байдлаар төлөвлөдөг зөрчлүүд жил бүр давтагдсаар байгаа тул алдаа, дутагдал гаргасан нэгж, албан тушаалтны ажлыг сайжруулах, хариуцлага тооцох.
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ Нийслэл, дүүргийн эрх бүхий худалдан авах ажиллагааны нэгжид шилжүүлж байх.
3. Эрх шилжүүлэхдээ гүйцэтгэгчийн нэрийг зааж захирамжлахгүй байх.
4. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож байх.

“УБЗЗАГ”, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-уудад:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн актуудыг бүрэн мөрдөх.




ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТГ**
Бодь цамхаг, Ц.Жигжидсүхийн гудамж-7/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0003
Утас: 31-16-30, 31-16-32, 32-42-49
Факс: (976-11) 32-46-23
http://www.invest.ub.gov.mn

2021.05.13 № 2/958
тантай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна.
Цаашид өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.




**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн засаг захиргааны IV байр, 15160-0066
Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809
E-mail: contact@ub-procurement.mn
http://www.ub-procurement.mn


2021.05.17 № 3/488
тантай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

"Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 25 хуудастай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



D:\Gargah\2021\1-37\488.docx
1150500227


**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР**
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 15160-0035
Утас/Факс: (076-11) 32-71-99
http://www.darg.gov.mn

2021.05.20 № 05/1996
тантай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын НАГ-2021/86-ШТА-ГА дугаартай тайлангийн төсөлтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/36 дугаар тогтоолоор баталсан 2020 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 120 багц ТАХ-г нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой эсэхийг тулгахад 661,698.6 сая төгрөгийн өртөгтэй, тухайн онд санхүүжих дүнгээр 155,830.3 сая төгрөгийн 38 багц ТАХ-г тодорхойгүй буюу ерөнхий нэрээр төлөвлөж, баталж байгаа нь анх төлөвлөгдсөн ТАХ болон төсөвт өртөг өөрчлөгдөх, зураг төсөвтэй батлагдах, өөр ажилд зарцуулах зэргээр төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.3.4 дэх заалт "санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл, нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах" заалтуудыг зөрчжээ.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-тэй уялдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлаг, дүүргүүдээс санал авч боловсруулсан.

Барилгын тухай хууль, Төсвийн тухай хуулиар зураг төсөлгүй, газар, техникийн нөхцөл шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно гэж заасны дагуу 2019 онд нийслэлд шинээр баригдах барилга, инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулахад 1.5 тэрбум төгрөгийг төлөвлөснөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын бэлтгэлийг ханган, барилга байгууламжийг хугацаанд нь чанарын өндөр түвшинд ашиглалтад өгөх, батлагдсан хөрөнгийг тухайн онд багтаан бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг НИТХ-ын тогтоолоор багц дүнгээр батлуулж, Нийслэлийн Засаг даргын захирамжаар төсөл, арга хэмжээний задаргааг нэр хүчин чадал, байршлаар баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Тухайлбал:

C:\2021он\албан бичиг\ХЕТХ.docx
111020001271

2

Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын системийн 4,500.0 сая төгрөгөөр нийслэлийн 9 дүүргийн Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх болон хая журмын камерууд, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалтыг хэрэгжүүлэхээр, Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө 25,000.0 сая төгрөгөөр 32 төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр, Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЗЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээний 2,000.0 сая төгрөгөөр 46 зураг төсөл боловсруулахаар, Сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын 1,000.0 сая төгрөгөөр 21 барилгын засварын ажил хийхээр, Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж худалдан авах 1,000.0 сая төгрөгөөр 42 нэр төрлийн тоног төхөөрөмж авахаар, Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний дундын зогсоолуудын тохижилтын 450.0 сая төгрөгөөр 15ш зогсоол, Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах 3,000.0 сая төгрөгөөр 7 дүүргийн 42 байршилд айл өрхийг цахилгаан хангамжаар хангахаар, Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах 2,000.0 сая төгрөгийн ажил нь 9 дүүргийн 18 байршилд, Хотын гол болон туслах гудамж замуудын засварын 7,000.0 сая төгрөгийн ажил нь 18 байршилд, Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт хийх, шилэн кабель татах ажил 22 байршилд, Гүр, хоолой, туннелийн засварын ажил нь 17 байршилд, Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн 2,000.0 сая төгрөгийн ажил нь 14 байршилд тус тус хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын захирамжаар задаргаа батлагдсан.

Дээрх багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний төсөл, арга хэмжээ нэг бүрээр батлах боломжгүй байдаг. Хэрэв хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нэг бүрээр НИТХ-ын тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх явцад төсөл, арга хэмжээний хүчин чадал, байршилд ямар нэгэн өөрчлөлт гарах тохиолдолд заавал НИТХ-д өргөн барьж төсвийн тодотгол хийх шаардлагатай болох бөгөөд энэ нь Төсвийн тухай хууль зөрчих, хугацаа алдах, худалдан авах ажиллагаа нь оройтох, хөрөнгийг төсвийн жилд нь багтаан зарцуулах боломжгүй болох зэрэг сөрөг үр дагавар гарна гэж үзэж байна.

Мөн нийслэл дэх төрийн Аудитын газраас Төсвийн тухай хуулийн 34.2.1-т дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, 34.2.2-т урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон, 34.2.3-т энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах" гэсэн заалтын нөхцөл бүрэлдээгүй байхад төсвийг удаа дараа өөрчлөн, тодотгож, төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний нэр, төсөвт өртөгт өөрчлөлт оруулж баталсан нь хууль зөрчих байна гэсэн дүгнэлтийг удаа дараа өгч байсан.

2.Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх ойролцоогоор 5-134 хоногээр хугацаа хэтэрч шилжиж ирснээс шалтгаалан ТАХ-ний сонгон шалгаруулалт, ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийн хугацаа алдагдах нөхцөл хүргэж байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг бууруулсан.



3

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор худалдан авах ажиллагааны эрхийг нийслэлийн төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор шилжүүлэн ажилласан.

Харин нийслэлийн 2020 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний хувьд тухай бүр захирамж гарч ажлын гүйцэтгэлээр санхүүждэг төсөл, арга хэмжээнүүд байдаг. Үүнд: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө 25,000.0 сая төгрөг, газар чөлөөлөх, нөхөх олговрын 20,000.0 сая төгрөгийг барилга байгууламжийн газар чөлөөлөх явцад иргэд, аж ахуйн нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр тухай бүр нь захирамж гардаг.

3 Нийслэлийн Засаг даргаас Хот тохижилтын газар болон "УБЗ3АГ" ОНӨААТҮГ-т эрх шилжүүлсэн 9,449.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-нд ТБОНӨХБАУХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуурыг магадлалгүйгээр тухайн газруудыг гүйцэтгэгчээр сонгож шууд гэрээ байгуулсан.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд 800 гаруй км авто замтай, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүсэж явган болон тээврийн хэрэгсэлтэй зорчигчдоод аюултай гэнэтийн онцгой нөхцөл байдал байнга үүсч байдаг.

Авто замын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаагүйгээс иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсныг хууль, хяналтын байгууллага тогтоосон бол тухайн авто зам хариуцагч болон эзэмшигч уг хохирлыг хариуцан төлнө" гэж заасан байдаг.

Нийслэлд авто замын байгууламжийг барих, засварлах, арчлах, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий 260 гаруй ажилчидтай "Улаанбаатар зам засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ гэсэн мэргэжлийн байгууллага ажилладаг.

Энэ байгууллага нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтад зааснаар "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг", 14.1.5 дахь заалтад зааснаар "тендэрт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой" бол тендерийн ерөнхий нөхцөл хангахгүй гэсэн заалтаар нийслэлийн төсөв, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ус зайлуулах байгууламж, шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажлын тендэрт оролцох эрх нь хязгаарлагдмал байдаг тул худалдан авах ажиллагаанд оролцох боломжгүй байдаг.

Мөн "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.5-т "Хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасан боловч нийслэлийн дээрх байгууллагыг Орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн чанартай замын засвар, арчилгаатай холбоотой ажил үйлчилгээ эрхэлдэг тул боломжгүй гэж тайлбарласаар ирсэн.

4

Нийслэлээс дээрх хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар удаа дараа холбогдох байгууллагуудад санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдэхгүй өдийг хүрээд байна.

Өнөөдөр Улаанбаатар хотын авто замыг засварлах, арчлах хөрөнгө нь нийслэлийн төсөвт батлагдсан, авто замыг засварлах, арчлах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагатай боловч "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн холбогдох заалтуудаас шалтгаалан нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөхөд хүрээд байна.

Нийслэлийн авто зам, замын байгууламжийг эвдрэл гарсан тухай бүр нь хугацаа алдалгүйгээр засварлах, нийслэлийн иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагын улмаас Нийслэлийн Засаг даргын захирамжаар "Улаанбаатар зам, засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ-аар авто зам, замын байгууламжийн арчлалт, өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийг зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг эргэн харах, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгнө үү.

Хот тохижилтын газрын хувьд "УБЗ3АГ" ОНӨААТҮГ-тай адил асуудлууд үүсч байгаа болно.

Цаашид Төрийн аудитын газраас гарсан дүгнэлтүүдийн дагуу тодорхой арга хэмжээ авч өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
ДАРГА

АМӨНХБӨЛД



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Нийслэлийн ЗД болон НАЗХГ-аас аудитын тайлангийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй.

"НХОГ" ОНӨААТҮГ-аас 2021 оны 5 дугар сарын 13-ны 2/958 дугаар албан бичгээр тайлангийн төсөлтэй танилцан, саналгүй бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

НХААГ-ын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 3/488 дугаар албан бичгээр ирүүлсэн 14 саналаас 1 саналыг хүлээн авч, 1 саналыг тийм/үгүй 12 саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 05/1996 дугаар албан бичгээр ирүүлсэн 3 санал тайлбарт няцаалт байхгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

	Ирүүлсэн санал	Саналыг хүлээн авсан эсэх	НТАГ-ын тайлбар
	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 3/488 дугаартай албан бичиг		
1.1	Тайлангийн Бүлэг 2.2-т "Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн салбар амбулаторийн барилгын их засвар" (БЗД, 7 дугаар хороо) төсөвт өртөг 48,2 сая төгрөг. Үнэлгээний хороо нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	НХААГ-ын даргын 2020.02.03 А/162 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж, 2020.04.03-ний өдөр 01 дүгээр хурлын зарлан хуралдаж тус хуралдаанаар ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдүүлэг бөглөхийг ҮХ-ний дарга мэдэгдсэн ч гишүүд мэдүүлгээ бүрэн бөглөөгүй. Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид бүрэн байгаагүй ба байгаа нь он саргүй тодорхой бус байсныг Үнэлгээний хорооны даргад тухай бүрд нь танилцуулсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
1.2	Тайлангийн Бүлэг 2.2-т "Онцгой байдлын газрын тусгай зориулалтын авто машин, багаж хэрэгсэл" төсөвт өртөг 86,0 сая төгрөг. Тендерийн баримт бичгийг батлахаас өмнө сонинд зарласан гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Баримтаар нотлогдоогүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Тайлангийн төсөлд ирүүлсэн саналын нотлон баримтын 4-5 дугаар хуудсанд ирүүлсэн тендерийн баримт бичиг нь он сар тодорхой бусаар өдөр тавилгүй баталсан.
1.3	Тайлангийн Бүлэг 2-т "Экскаватор (1ш) төсөвт өртөг 520,0 сая төгрөг. Тендерийн баримт бичиг батлаагүй байхад урилга илгээсэн гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Үнэлгээний хороо 2020.05.10-нд хуралдаж, 2020.05.11-нд Засгийн газрын мэдээ сонинд урилга нийтэлсэн. Тендерийн баримт бичгийг 2020.05.13-ны өдөр батлуулсан. Тайлангийн саналд ирүүлсэн нотлох баримт нь аудитын явцад зөрчил дутагдлыг хэлэлцэн танилцуулсан тул хүлээн авах боломжгүй.
1.4	"15 дугаар сургуулийн спорт заалны барилга" (ХУД, 3 дугаар хороо) төсөвт өртөг 699,9 сая төгрөг. Тендерийн баримт бичиг батлаагүй байх хугацаанд урилга илгээсэн гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зарлаж 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр нээлт хийхэд нэг ч компани материал ирүүлээгүй тул дахин 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зарлаад 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр нээлт хийсэн. Уг үед ковид гарсантай холбоотойгоор цахимаар ажиллаад цахимаар батлагдсан байсан. Тайлбарыг хүлээн авах боломжгүй.
1.5	"Сургуулийн барилга худалдан авах 640 суудал" (БЗД, 22 дугаар хороо) төсөвт өртөг 5,100,0 сая төгрөг. Тендер хүчинтэй байх хугацаанд үнэлээгүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Уг ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар 2, гэрээ шууд байгуулах аргаар 3 удаа зарласан. 2020.02.10-нд зарласан тендерийг 2020.03.10-нд нээхээр байсан, нэг ч оролцогч материалаа ирүүлээгүй бөгөөд тендерийн хүчинтэй байх хугацаа ТӨӨЗ 20.1 дээр 30 хоногоор заажээ. Үнэлгээний хороо 2020.04.23-нд хуралдаж 2020.04.24-нд тендер зарласан нь 44 хоногийн



			дараа зарласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 24.5-г зөрчсөн.
1.6	Удирдлагын академийн урд “СМАЙЛ” хүнсний дэлгүүрээс Туул голын далангийн эрэг хүртэлх авто зам (ХУД) төслийн төсөвт өртөг 241,8 сая төгрөг. Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Баримтаар нотлогдоогүй тул тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
1.7	“131 дүгээр цэцэрлэгийн засвар” (БНД, 1 дүгээр хороо) төслийн төсөвт өртөг 49,9 сая төгрөг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан нотлох баримт байхгүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	ТАХ-г 7 удаа зарласан. 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт, 5 удаа гэрээ шууд байгуулах аргаар зарласан. Архивын материалд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан материал бүрэн байгаагүй ба санал ирүүлсэн нотлох баримт 2020.05.20-ны өдрийнх байна. Аудитаар эхний удаа зарласан ба 2020.03.20-ны хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан баримт байгаагүйг тусгасан болно. Үнэлгээний хорооны нарийн бичигт зөрчил дутагдлыг танилцуулж хүлээн зөвшөөрсөн.
2.1	“115 дугаар цэцэрлэг (БЗД, 5 дугаар хороо) төсөвт өртөг 85,8 сая төгрөг. Шалгарсан “Ган хэлхээ констракшн” ХХК нь ТББ-д экскаватор өмчлөгчтэй түрээсийн гэрээ байгуулаагүй. Инженер техникийн ажилчдын туршлага ТӨӨЗ-д заасан шаардлага хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Тендер шалгаруулалтыг өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлээгүй. ТӨӨЗ-д заасан тоног төхөөрөмж тээврийн хэрэгслийг түрээсийн гэрээ байгуулахдаа тухайн өмчлөгчтэй байгуулаагүй. Экскаватор өмчлөгч нь Ц.Батбилэг, гэтэл тухайн гэрээг байгуулсан иргэн П.Ламжав нь өмчлөгч биш тул хүлээн авах боломжгүй. Инженер техникийн ажилчдын туршлагыг ТӨӨЗ-д заасан шаардлагыг хангасан гэх нотлох баримтыг ирүүлээгүй. Аудитаар Тухайн үнэлгээний хорооны даргад танилцуулж тулган баталгаажуулсан болно.
2.2	“Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн Хүүхдийн эмнэлэг засвар” (БГД, 17 дугаар хороо) Багц-1 төсөвт өртөг 25,9 сая төгрөг. Шалгарсан “Ажнай шарга” ХХК нь ажлын талбайтай танилцсан тухай ашиглагч байгууллагын тодорхойлолт, тэмдэглэл, фото зураг, ижил төстэй ажлын захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй. Барилгын инженер байхгүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	ТАХ-г зохион байгуулсан үнэлгээний хороо нь ТШӨХ-д заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлээгүй. Шалгарсан “Ажнай шарга” ХХК-ийн Ажлын талбайтай танилцсан тухай ашиглагч байгууллагын тодорхойлолт, тэмдэглэл, фото зургийн хамт, ижил төстэй ажлын захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ гэж заасныг ирүүлээгүй байхад шалгаруулсан. Барилгын инженер гэж ирүүлсэн Б.Долгоржав нь тус кампанийн ерөнхий инженер ТШӨХ-д ерөнхий инженер болон барилгын инженер гэж тусад нь заасан.
2.3	“Налайх дүүргийн нутгийн захиргааны байр (НД 7дугаар хороо) төсөвт өртөг 14,268,0 сая төгрөг. Шалгарсан гүйцэтгэгч “Рино Инженеринг” ХХК-ийн Түншлэгч ТӨӨЗ-ийн 6.1-д заасны дагуу 5.2 дахь заалтыг хангасан байх шаардлагыг хангаагүй, ижил төстэй ажил гүйцэтгэсэн улсын комиссын акт, ажлын зураг ирүүлээгүй, дулааны инженер нь ТӨӨЗ-д заасан шаардлага хангаагүй, нийт инженер техникийн ажилчдын 50-иас доошгүй хувь нь үндсэн ажилтан байна гэсэн шаардлага хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Баримтаар нотлогдоогүй тул тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Л.Одхүү танилцаж хүлээн зөвшөөрсөн.
2.4	“Гацуурт ХХК-аас баруун тийш Хилийн цэргийн 164 дүгээр анги хүртэлх авто зам” (БГД, 20 дугаар хороо) төсөвт өртөг 961,1 сая төгрөг. Шалгарсан “Уулын зам” ХХК-ний геодезийн инженер нь ТӨӨЗ-д заасан шалгуур хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Тийм/Үгүй	Хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ гэсний дагуу шалгаруулсан байна.
2.5	“Ургах наран хороололд тохижилт тоглоомын талбай” (БЗД, 11 дүгээр хороо) төсөвт өртөг 43,2 сая төгрөг. Шалгарсан “Кайхацү” ХХК-ний Ерөнхий инженерийн ажилласан жил ТӨӨЗ-д заасан шалгуур хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Тийм	Санал тайлбарыг хэлэлцэн аудитын тайлангаас зөрчил дүгнэлтийг хассан.
2.6	“Сургуулийн барилга 640 суудал” (ЧД, 8 дугаар хороо) төсөвт өртөг 4,791,2 сая төгрөг. Шалгарсан гүйцэтгэгч “Лакилайф” ХХК нь архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг	Үгүй	Шалгарсан гүйцэтгэгч “Лакилайф” ХХК нь архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлалыг



	төсөл боловсруулах даалгаврын дагуу ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлалыг ирүүлээгүй, материалын инженерийн ажилласан жил нь ТӨӨЗ-д заасан шалгуур хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.		ирүүлээгүйг нотлох баримт байхгүй. ТӨӨЗ 6.2 (в) Материалын инженерээр ажиллах ажилтны туршлагыг 3 болон түүнээс дээш гэж заасан боловч шалгарсан компанийн материалын инженер Н.Гантулга нь 2020.04.10-ны өдөр материалын технологич инженерээр ажилласан нь ажилласан жилийн шаардлага хангаагүй байна.
2.7	“Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар номын сангуудын тоног төхөөрөмж” Багц-2 төсөвт 93,5 сая төгрөг. Шалгарсан “Оолинк”ХХК- ний Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь ТӨӨЗ-д заасан шаардлага хангаагүй гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.	Үгүй	Баримтаар нотлогдоогүй тул тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй.



ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

Тогтоолд орсон өөрчлөлтөөр хасагдаж, нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт
(2020 онд хэрэгжих)

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Агаар орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах "Хөгжлийн үүд" төсөл	2020-2021	50,000.0	5,000.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
2	Орон сууц, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2020-2021	50,000.0	5,000.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
3	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 26 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол	2020	200.0	200.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
4	Хот төлөвлөлт, судалгааны институтийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж	2020	250.0	250.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
5	Улаанбаатар хотын олон нийтийн оролцоотой хот төлөвлөлтийн нэгдсэн систем	2020-2021	2,630.0	300.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
6	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /23ш/	2020-2022	73,600.0	10,000.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
7	Сургуулийн барилга 640 суудал /БЗД, 14 дүгээр хороо/	2020-2022	5,100.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
8	Сургуулийн барилга 640 суудал /ХУД, 4 дүгээр хороо/	2020-2022	5,100.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
9	Цэцэрлэгийн барилга 240 ор /ХУД, 4 дүгээр хороо	2020-2021	2,200.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
10	Цэцэрлэгийн барилга 240 ор /БЗД, 14 дүгээр хороо	2020-2021	2,200.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
11	Цэцэрлэгийн барилга 240 ор /НД, 4 дүгээр хороо	2020-2021	2,200.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
12	Цэцэрлэгийн барилга 100 ор /ЧД, 16 дугаар хороо	2020-2021	1,200.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
13	58 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны хоолны газрын өргөтгөл /СБД/	2020-2021	300.0	50.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
14	Спорт заалны барилга /БХД, 2 дугаар хороо/	2020-2021	1,200.0	400.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
15	Улаанбаатар хотын зүүн, баруун талд хүнсний бөөний төв байгуулах	2020-2021	5,000.0	2,500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
16	Гэр хороолол доторх холбоос замуудыг шинээр барих	2019-2020	6,955.7	3,965.7	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
17	Ахмадын хорооллын орчмын Нарны зам, Дүнжингаравын авто замыг холбосон төмөр зам доогуурх явган зорчигч автомашинд зориулсан нүхэн гарц, авто зам /БЗД/	2019-2020	3,340.1	2,140.1	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
18	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2020-2021	16,408.4	11,408.4	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
19	Усан сангийн талбай, цэцэрлэгт хүрээлэн /СХД, 10 дугаар хороо/	2020	200.0	200.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
20	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажил	2020-2021	8,000.0	2,000.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
21	Гэр хороолол доторх авто зам	2020-2021	45,548.5	14,498.5	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ



Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

22	Туслах гудамж зам болон орон сууцны хороолол доторх холбоос замуудыг шинээр барих болон шинэчлэх, гудамж замуудын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах	2020-2021	23,000.0	10,550.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
23	Нийтийн тээврийн хэрэгслийн зориулалтын зогсоол	2020	300.0	300.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
24	Асфальт бетон хольц дахин боловсруулах үйлдвэр	2020-2021	1,500.0	500.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
25	Магадалшгүй ажил	2020	1,000.0	1,000.0	НИТХ-ын 2019.12.16 9/36 тогтоолоос хасагдсан ТАХ
26	Баянхошуу бизнес инкубатор дэд төвийн засвар, тохижилтын ажил	2020	46.4	46.4	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
27	Багахангай дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ажлын байрны засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авах	2020	27.0	27.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
28	Ухаалаг ус түгээх цэгийн байр /2ш/ НД 5,8 дугаар хороо	2020-2021	97.3	10.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
29	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад /БГД, НД	2020-2021	1,999.7	200.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
30	Налайх-Чойрын чиглэлийн авто замын уулзвараас Төмөр замын 5 шар байшингийн баруун тал хүртэлх 4.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын санхүүжилт-1 /эхний хэсэг/ /НД/	2019-2020	4,382.0	2,174.6	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
31	Толгойтын эцсээс баруун тийш үргэлжлэх авто зам /СХД, 2 дугаар хороо/	2019-2020	767.0	376.6	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
32	ЖДҮД төвийн урд уулзвараас Шунхлай ШТС хүртэлх хатуу хучилттай авто замын ажил /1 дүгээр хэсэг, /БНД, 3 дугаар хороо/	2019-2020	798.3	398.3	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
33	Гэр хорооллын шороон замыг сайжруулах, авто замын хурд сааруулагч, хэвтээ тэмдэглэгээний ажил	2020	56.0	56.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
34	Сүхбаатарын талбайн урд байрлах Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийн ажил	2020-2021	3,788.4	2,858.9	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
35	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд хэрэгжүүлэх "Блю скай" зочид буудлын зүүн талын гадна талбайн тохижилт	2020-2021	519.8	100.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
36	Дүүргийн төвлөрсөн хогийн цэгийн нөхцөлийг сайжруулах /БНД, 3 дугаар хороо/	2020-2021	332.1	50.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
37	6-9 дүгээр байрны дундах тохижилт /БНД, 1 дүгээр хороо /	2020-2021	271.2	216.9	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
38	Сагасан бөмбөгийн талбайн тохижилт /НД/	2020-2021	610.2	237.2	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
39	Хөрөнгө оруулалт, талбайн тохижилтын ажил	2020-2021	117.7	5.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
40	Шувуун фабрик-Сонгино чиглэлийн авто замын Туул гол дээрх 256 у/м төмөр бетон гүүрний их засварын ажил /ХУД, 12 дугаар хороо/	2020-2021	6,966.6	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
41	31 дүгээр хорооноос эгц хойшоо гадна тойруу хүртэлх авто зам /СХД, 31 дүгээр хороо/	2020-2021	2,395.1	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
42	Цэргийн амралтаас хойш үргэлжлэх 1.0 км авто зам /СБД, 19 дүгээр хороо/	2020-2021	1,406.2	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ



43	13, 16 дугаар гудамжны дунд хэсгийн сайжруулсан хайрган хучилттай авто зам /БГД, 22 дугаар хороо/	2020	329.3	329.3	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
44	Цагдаагийн хангамж үйлчилгээний төвийн зүүн талын 0.7 км авто зам /БЗД, 10 дугаар хороо/	2020	971.0	971.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
45	Цагдаагийн 2 дугаар хэлтсийн баруун талаар 163, 78 дугаар цэцэрлэг рүү орсон гудамжны авто зам /СХД/	2020	341.0	341.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
46	Хороо хоорондын замыг Улаанбаатар-Чойр чиглэлийн авто замтай холбох 1.3 км авто зам /БХД, 1 дүгээр хороо/	2020-2021	1,628.3	634.1	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
47	Авто зам гүүрний ажил /СБД, 15,16 дугаар хороо/	2020-2021	3,970.2	900.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
48	138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэг явах авто зам /ЧД, 12 дугаар хороо/	2020-2021	586.1	300.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
49	Налайх-Чойрын чиглэлийн авто замын уулзвараас төмөр замын 5 шар байшингийн баруун тал хүртэлх 4.4 км авто замын ажил /2дугаар хэсэг/ НД 2,3,7 дугаар хороо/	2020	2,744.0	2,744.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
50	Буяны авто замаас Толгойтын эцэс хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 3 дугаар хороо/	2020	678.1	678.1	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
51	Наадамчдын замаас "Агапе" эмнэлгийн баруун тал гэр хорооллын дундуур Буянт-Ухаа цогцолбор сургууль хүртэлх авто зам /ХУД/	2020-2021	994.1	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
52	Чингэлтэй дүүргийн авто зам байгууламжийн ажил	2020	1,392.6	1,392.6	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
53	ЖДҮД төвийн урд уулзвараас Шунхлай ШТС хүртэлх хатуу хучилттай авто замын ажил /2 дугаар хэсэг, /БНД, 3 дугаар хороо/	2020	628.0	628.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
54	Баянхошууны авто замаас зүүн тийш 264 дүгээр цэцэрлэгийн урдуур Баянхошууны эцсийн буудал хүртэлх туслах замтай холбох хатуу хучилттай авто зам /СХД, 28 дугаар хороо/	2020-2021	2,779.0	700.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
55	Хувьсгалчдын гудамжнаас Хонхорын 6-177 6 хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 11 дүгээр хороо/	2020-2021	1,590.6	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
56	Хан-Уул дүүргийн Эх хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн төвийн гадна авто зам, орц, гарцыг шинээр барих ажил	2020	194.1	194.1	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
57	ШШГЕГ-ын харьяа 461 дүгээр ангийн баруун талаас Баянгол агро паркийн хойд хаалга хүртэлх шинэ авто зам /БГД, 20 дугаар хороо/	2020-2021	494.8	250.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
58	Гацуурт ХХК-аас баруун тийш Хилийн цэргийн 164 дүгээр анги хүртэлх авто зам /БГД, 20 дугаар хороо/	2020-2021	961.1	500.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
59	Удирдлагын академийн урд талын "Смайл" хүнсний дэлгүүрээс Туул голын далангийн эрэг хүртэлх авто зам /ХУД/	2020	241.8	241.8	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
60	УБ-Багануур чиглэлийн авто замаас 4 дүгээр хорооны Алтай хэсгийн "Божу" ХХК-ийн хүнсний дэлгүүр хүртэлх авто зам	2020-2021	2,949.1	1,018.1	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
61	Замчны 1 дүгээр гудамжнаас Замчны 36 гудамж хүртэлх авто зам /НД, 3 дугаар хороо/	2020	1,687.9	1,687.9	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
62	Санзайн авто замын засвар, шинэчлэлтийн ажил	2020-2021	2,749.0	1,000.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ



Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

63	Сайжруулсан түлшний үйлдвэр хүртэлх авто зам /СХД, 20 дугаар хороо/	2020	1,318.1	1,318.1	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
64	МТ шатахуун түгээх станцаас Амгалан хотхон хүртэлх авто зам /2 дугаар хэсэг/, /БЗД, 16 дугаар хороо/	2020	148.0	148.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
65	Цагаан байрны хойд уулзвараас далан дагаад Хүчит шонхор захын уулзвар хүртэлх авто зам /1 дүгээр хэсэг/ /ЧД, 10 дугаар хороо/	2019-2020	980.2	480.2	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
66	"Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-аас Налайх чойрын чиглэлийн авто замтай холбох 4,64 км авто замын санхүүжилт-2 /эхний хэсэг/ /НД/	2018-2020	8,827.5	1,770.9	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
67	Налайх-Чойрын чиглэлийн авто уулзвараас Төмөр замын шар байшингийн баруун тал хүртэлх 4.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын санхүүжилт-2 /эхний хэсэг/ /НД/	2019-2020	4,382.0	535.4	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
68	Унадаг дугуйн замын ажил санхүүжилт-1 /БАГЦ-1/ /БЗД, ХУД/	2020-2021	9,796.4	1,950.0	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
69	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажил	2020	1,713.2	1,713.2	НИТХ-ын 2020.11.13 II-02/06 тогтоолоор нэмэгдсэн ТАХ
НИЙТ			387,089.2	104,945.4	



Хавсралт №2

Тогтоолд орсон өөрчлөлтөөр нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт
(Он дамжин хэрэгжих)

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжихээр батлагдсан дүн	2019-2020 он дамжин санхүүжих дүн
1	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй сургууль, цэцэрлэгт жишиг ариун цэврийн байгууламж барих /4ш/	2019-2020	320.0	80.0	71.9
2	"Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын автобусны угаалгын төвүүдийн тоног төхөөрөмж	2019-2020	900.0	900.0	275.4
НИЙТ			1,220.0	980.0	347.3



Хавсралт №3

Ерөнхий нэрээр баталсан ТАХ-ний жагсаалт

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1	Нийтийн тээврийн шинэ шийдэл төсөл, парк шинэчлэлт, хүүхдийн сургуулийн автобус	2020-2023	350,000.0	26,050.0
2	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /23ш/	2020-2022	73,600.0	10,000.0
3	Гэр хороолол доторх авто зам	2020-2021	45,548.5	14,498.5
4	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө	2020	25,000.0	25,000.0
5	Туслах гудамж зам болон орон сууцны хороолол доторх холбоос замуудыг шинээр барих болон шинэчлэх, гудамж замуудын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах	2020-2021	23,000.0	10,550.0
6	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилга II ээлж /СХД, 22 дугаар хороо	2019-2022	18,500.0	2,000.0
7	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2020-2021	16,408.4	11,408.4
8	Унадаг дугуйн зам	2020-2021	16,000.0	6,000.0
9	Теле камер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем	2020-2021	15,000.0	4,500.0
10	Гэр хороолол, орон сууцны дэд бүтцийн ажил	2019-2020	8,845.0	1,470.0
11	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажил	2020-2021	8,000.0	2,000.0
12	Хотын гол болон туслах гудамж замуудын засвар	2020	7,000.0	7,000.0
13	Гэр хороолол доторх холбоос замуудыг шинээр барих	2019-2020	6,955.7	3,965.7
14	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /4ш/	2020-2021	6,309.3	2,250.0
15	Эмнэлгүүдийн гадна талбайн тохижилтын ажил /6ш/	2019-2020	5,981.6	3,981.6
16	Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил	2020-2021	5,000.0	3,000.0
17	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний зориулалтын автомашин /40ш/	2020-2021	4,800.0	3,360.0
18	Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөл	2020-2021	4,000.0	2,000.0
19	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	2019-2020	3,109.7	1,555.7
20	Жишиг гудамж /СХД/	2020-2021	2,900.0	500.0
21	Гэр хороолол, орон сууцны доторх зам, засвар, ус зайлуулах шугам, худгийн засвар өргөтгөл /БГД/	2020	2,166.4	2,166.4
22	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил	2020-2021	2,000.0	1,000.0
23	Шинээр баригдаа барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ	2020	2,000.0	2,000.0
24	Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар	2020	1,000.0	1,000.0
25	Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж	2020	1,000.0	1,000.0
26	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт хийх, шилэн кабель татах ажил	2020	1,000.0	1,000.0
27	Гүүр, хоолой, туннелийн засварын ажил	2020	1,000.0	1,000.0
28	Онцгой байдлын газрын тусгай зориулалтын авто машин, багаж, хэрэгсэл	2020	990.0	990.0
29	Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, засвар шинэчлэлт хийх төсөл /СХД, БЗД/	2020	975.0	975.0



Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

30	Стандартад нийцсэн хөл бөмбөг, биеийн тамир чийрэгжүүлэлтийн талбай	2020	779.0	779.0
31	Нийслэлийн Төр захиргааны авто баазын авто машины парк шинэчлэлт, засварын тоног төхөөрөмж, барилгын засвар	2020	500.0	500.0
32	Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар	2020	500.0	500.0
33	Сургууль цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил	2020	500.0	500.0
34	Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний дундын зогсоолуудын тохижилт	2020	450.0	450.0
35	Нийслэлийн соёлын байгууллагуудын барилгын засвар	2020	300.0	300.0
36	Нийтийн тээврийн хэрэгслийн зориулалтын зогсоол	2020	300.0	300.0
37	Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар номын сангуудын номын фондын баяжилт, тоног төхөөрөмж	2020	200.0	200.0
38	Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хороодоос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	2020	80.0	80.0
НИЙТ			661,698.6	155,830.3



Хавсралт №4

Үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал

(сая.төг)

№	ТАХ-ний нэр, хүчин чадал байршил	Ирүүлсэн үнийн санал /НИТХ-ын 9/36 дугаар тогтоол/	ТАХ зохион байгуулсан газар	Шалгарсан оролцогчийн нэр	Тайлбар
1	“Монгол тэмүүлэл” сургуулийг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн хичээлийн 1 дүгээр байранд шилжүүлэн сургалтын үйл ажиллагааг явуулах болсонтой холбогдуулан тус байрны танхимын засварын ажил	27.4	НЗДТГ	Жи Эн Зэт Эф Икс ХХК	Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
2	Цэцэрлэгийн барилгын дуусгал 100 ор /СХД, 5 дугаар хороо/	264.0	НХОГ	Арьконстракшн ХХК	Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
3	Хямд өртөгтэй орон сууцны барилга угсралтын ажил Багц-2 /СБД, 11 дүгээр хороо/	1,587.4		Баярс констракшн ХХК	Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
4	Туул тосгоны эмнэлгийн барилга /ХУД, 13 дугаар хороо/	733.1		НЬЮ КОНСТРАКШН ХХК	Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
5	Нөхөөс Багц-4	63.4	УБЗЗАГ	Шидэт шал ХХК	Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
6	Нөхөөс Багц-6	69.4	ОНӨААТҮГ		Тендерийн баримт бичгийг огноо дугааргүй баталсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22.1 Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэсэн заалтыг зөрчиж байна.
